

Эдийн засгийн хамтын ажиллагааны бодлого хариуцсан ахлах мэргэжилтэн, Сайнжаргал Анхсайхан

2025 ОНЫ ХАГАС ЖИЛ-Н ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

НЭГ. ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин / биелэлт	Эхэлсэн, дууссан хугаца	Биелэлтийн хувь
1.1. Худалдаа, эдийн засгийн гадаад хамтын ажиллагаа болон гадаад, дотоод худалдааны бодлогыг тодорхойлох, нэгдсэн төлөвлөлт, зохицуулалтаар хангах, холбогдох гэрээ, хэлэлцээрийг тохиролцох, байгуулах, хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох, хэрэгжилтэд хяналт тавих;							
1	Хоёр болон олон талт эдийн засгийн хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэх чиглэлийг тодорхойлж, хамтын ажиллагааны нэгдсэн бодлого боловсруулах, төлөвлөх, зохицуулах, холбогдох гэрээ, хэлэлцээрийг тохиролцох, байгуулах, хамтран ажиллах, хэрэгжилтийн үр ашгийг сайжруулахад чиглэсэн арга хэмжээ	Хэрэгжилтийн явц, хувиа	Тухай бүр шаардлагатай арга хэмжээг авч ажилласан болно.	Тухай бүр шаардлагатай арга хэмжээг авч ажилласан байна. /100 хувь/	А. Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүх 2025 оны 1 дүгээр сард БНТУ-д хийсэн төрийн айлчлалын ажлын хэсэгт ажиллаж дараах үүргийг амжилттай гүйцэтгэв. Үүнд: - Айлчлалын үндсэн чиглэл, яриа хэлэлцээний сэдэвт санал боловсруулан хүргүүлэв. - Айлчлалаар Туркийн талтай байгуулсан боловсрол, эрүүл мэнд, байгаль орчин, ойн аж ахуй, залуучууд,	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100%

авна.

спортын салбарт
хамтран ажиллах тухай
Засгийн газар
хоорондын 8
хэлэлцээрийг
урьдчилан судлан үзэж
санал хүргүүлсэн.
Тэдгээр хэлэлцээрийг
батлах асуудлаар мөн
санал хүргүүлсэн. -
Анкара, Истанбул
хотноо зохион
байгуулагдсан бизнес
форумыг холбогдох
талуудтай хамтран
зохион байгуулж
форумын синхрон
орчуулгыг хийж
гүйцэтгэсэн. Форумг
нээж Тэргүүн шадар
сайд бөгөөд Эдийн
засаг, хөгжлийн сайдын
хэлэх үгийн төслийг
боловсруулсан. -
Тэргүүн шадар сайд
бөгөөд, ЭЗХС-ын
зүгээс Туркийн талтай
хийсэн албан ёсны
уулзалтын ярианы
сэдвийг боловсруулж
уулзалтыг зохион
байгуулсан. Б. Дараах
айлчлал, арга
хэмжээний үеэр
баримтлах үндсэн
чиглэл, яриа
хэлэлцээний сэдэвт
санал боловсруулж
хүргүүлсэн. Үүнд: -

					Ерөнхийлөгч У.Хүрэлсүх 2025 оны 3- р сард БНЧУ, БНПУ-д хэрэгжүүлсэн төрийн айлчлал; - ГХ-ны сайд Б.Батцэцэг 2025 оны 2- р сард Оманы Султант Улсад хийсэн албан ёсны айлчлал; - Монгол, Ираны ГХЯ хоорондын II зөвлөлдөх уулзалт; - Монгол, Эмиратын ЗГХЭЗХХ- ны I хуралдаан; В. Дараах хэлэлцээрийн төсөлд санал боловсруулан хүргүүлэв. Үүнд: - Визийн шаардлагаас харилцан чөлөөлөх тухай Монгол Улс, Колумби Улсын ЗГ хоорондын хэлэлцээр /01/38 дугаар албан бичгээр/ ; - Агаарын харилцааны тухай Монгол, Кувейтын ЗГ хоорондын хэлэлцээр /01/377/; - Дипломат паспорт эзэмшигчдийг визийн шаардлагаас чөлөөлөх тухай Монгол Улс, Бахрейн Улсын ЗГ хоорондын хэлэлцээр /01/809/; - Соёлын салбарт хамтран ажиллах тухай Монгол, Катарын ЗГ хоорондын хэлэлцээр /01/684/; -
--	--	--	--	--	---

					Боловсролын салбарт хамтран ажиллах тухай Монгол, Катарын ЗГ хоорондын хэлэлцээр /01/1325/. Г. Айлчлал, арга хэмжээний мөрөөр хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Хавсралт: 1 файл		
2	Түнш орон, олон улсын болон бүс нутгийн байгууллагуудын болон тэдгээртэй хийж буй хамтын ажиллагааны мэдээллийн сан, цахим архив бүрдүүлэн баяжуулалтыг тухай бүр хийнэ.	Хэрэгжилтийн явц, хувиар	Түнш орон, олон улсын болон бүс нутгийн байгууллагуудын болон тэдгээртэй хийж буй хамтын ажиллагааны мэдээллийн сан, цахим архив бүрдүүлэн баяжуулалтыг тухай бүр хийж ажилласан.	Түнш орон, олон улсын болон бүс нутгийн байгууллагуудын болон тэдгээртэй хийж буй хамтын ажиллагааны мэдээллийн сан, цахим архив бүрдүүлэн баяжуулалтыг тухай бүр хийж ажиллана. /100 хувь/	Түнш улс орон, олон улсын болон бүс нутгийн байгууллагуудын тухай болон тэдгээртэй хөгжүүлж буй хамтын ажиллагааны мэдээллийн сан, цахим архивыг бүрдүүлэн, баяжуулалтыг тухай бүр хийж, мэдээллийг эргэлтэд оруулж ажиллав. Тухайлбал Америк тив, БНТУ, Ойрхи Дорнодын улс орнууд, ОУХТ болон тэдгээртэй хөгжүүлж буй эдийн засгийн хамтын ажиллагаа, анхаарвал зохих асуудлын талаар мэдээллийн сан, цахим архив бүрдүүлэн тухай бүр судалгаа хийн баяжуулж, мэдээллийг	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100%

эргэлтэд оруулж
ажилласан. Ингэхдээ
харилцааны лавлахыг
тухай бүр шинэчлэн,
уулзалт, арга
хэмжээний ярианы
сэдэв, тэмдэглэлийг
тухай бүр
боловсруулан
албажуулж TEAMS-ийн
холбогдох цэсэд
оруулахын сацуу
холбогдох яамд,
газруудад цаг
хугацаанд нь хүргүүлж
ажилласан болно. Мөн
түүнчлэн нууц албан
бичиг боловсруулах
ажлын хүрээнд өөрийн
хариуцан ажилладаг
улс орон, хөгжлийн
түнш байгууллагуудаас
гадна Зүүн Европын
улс орнууд болон
холбогдох олон улсын
байгууллагуудтай
хамтын ажиллагааны
мэдээллийн санг ч мөн
бүрдүүлэн ашиглаж
байна. Мэдээллийн
санг бүрдүүлэхдээ дан
ганц дотоодын эх
үүсвэрээр
хязгаарлахгүйгээр
Гадаад харилцааны
яам, Сангийн яам,
Аюулгүй байдал
судлалын хүрээлэн
зэрэг холбогдох

					байгууллагуудын ажиллагсадтай ажлын шугамаар холбогдож, зохих мэдээллийг авч, албан хэрэгцээнд ашиглаж ирсэн болно.		
3	Хөгжлийн түншүүдтэй хамтран хэрэгжүүлэх зээл, тусламжийн бодлогыг судалж, хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэх арга хэмжээг зохион байгуулж, санал боловсруулна.	Хэрэгжилтийн явц, хувиар	Хөгжлийн түншүүдтэй хамтран хэрэгжүүлэх зээл, тусламжийн бодлогыг судалж, хамтын ажиллагааг хөгжүүлэн ажилласан.	Тухай бүр санал боловсруулж, танилцуулсан байна. /100 хувь	А. Гадаадын зээл, тусламжаар хэрэгжүүлж буй төсөл, арга хэмжээ, хэрэгжиж дууссан төсөл, цаашид хэрэгжүүлэхээр хэлэлцэж буй төсөл, арга хэмжээний мэдээллийг хөгжлийн түнш бүрээр гарган нэгтгэж матриц үүсгэсэн. Б. Монгол Улсын хөгжлийн 2026 оны жилийн төлөвлөгөөний төсөл, дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд санал хүргүүлэхтэй холбогдуулан гадаадын зээл, тусламжаар хэрэгжүүлэх төсөл нэг бүрийг бодлогын баримт бичигт туссан байдал, бэлэн байдал хангагдсан байдал, эдийн засгийн үр өгөөж, нийгмийн ач холбогдлоор үнэлэх, эрэмбэлэх үйл ажиллагааг	1-р сар, 2- р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100%

гүйцэтгэсэн. В. Монгол
Улсын Ерөнхийлөгч
У.Хүрэлсүхийн БНТУ-д
хийсэн айлчлалын
мөрөөр хэрэгжүүлэх
арга хэмжээний
төлөвлөгөөнд туссан
Хавдар судлалын II
төвийн санхүүжилтийг
шийдвэрлэх асуудлаар
салбарын яаманд
дэмжлэг үзүүлэн
холбогдох
зохицуулалтыг хийж
гүйцэтгэн ажиллаж
байна. Мөн айлчлалын
мөрөөр Монгол Улсын
Шадар сайдаас Онцгой
байдлын салбарт
хэрэгжүүлэхээр дэмжин
ирүүлсэн төслийн
саналыг судлан үзэж
2025 оны 03/523 дугаар
албан бичгээр Туркийн
хамтын ажиллагаа,
зохицуулах агентлагт
уламжилсан. Г. АНУ-
ын Ерөнхийлөгч
Доналд Трампын 2025
оны 1 дүгээр сарын 20-
нд гаргасан "АНУ-ын
гадаад тусламжийг
дахин үнэлж шинэчлэн
хуваарилах тухай"
захирамжтай
холбогдуулан АНУ-ын
Мянганы сорилтын
корпорацын 350 сая
ам.долларын

			санхүүжилтээр хэрэгжүүлж буй "Улаанбаатар хотын ус хангамжийг нэмэгдүүлэх" төсөл (2021-2027)-ийн үйл ажиллагаатай холбогдуулан цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар санал боловсруулж Сангийн яаманд хүргүүлсэн болно.	
--	--	--	--	--

1.2. Импортыг орлох салбарыг дэмжиж, экспортын өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, худалдааны тэнцлийг сайжруулахад чиглэсэн бодлого боловсруулах, Монгол Улсын нэгдэн орсон, байгуулсан олон талт болон хоёр талт худалдааны гэрээ, хэлэлцээрийн хэрэгжилтийн үр ашгийг сайжруулах арга хэмжээ авах, шинээр гэрээ хэлцэл байгуулах санал гаргах, боловсруулах, худалдаанд тулгарч буй саад хүндрэлийг багасгаж, хөнгөвчлөх бодлого тодорхойлох, нэгдсэн төлөвлөлт, зохицуулалтаар хангаж, худалдааны (экспорт, импорт) санхүүжилтийн үйл ажиллагааны эрхлэх чиг үүргийн хүрээний асуудлаар Монгол Улсын Хөгжлийн банкны үйл ажиллагааг бодлогоор зохицуулах, чиглүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих;

4	Эдийн засаг, худалдааны чиглэлээр байгуулсан олон талт болон хоёр талт гэрээ, хэлэлцээрийн хэрэгжилтийг үр ашгийг сайжруулахад чиглэсэн арга хэмжээ авч, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллана.	Хэрэгжилтийн явц, хувиар	Монгол Улс нь Дэлхийн худалдааны байгууллагын гишүүн ба Ази номхон далайн худалдааны хэлэлцээр, Ази номхон далайн хил дамнасан цаасгүй худалдааг хөнгөвчлөх тухай хэлэлцээр, Европын холбооны хөнгөлөлтийн ерөнхий системд тус тус нэгдэн орсон байх ба Япон улстай Эдийн засгийн түншлэлийн хэлэлцээр байгуулсан.	Тухай бүр судалгаа хийн дүгнэлт гаргаж, санал боловсруулан, холбогдох арга хэмжээг авч ажилласан байна. /100 хувь/	А. 2023 онд байгуулсан "Стратегийн гуравдагч хөршийн түншлэлийн эдийн засгийн хамтын ажиллагааны тухай Монгол Улсын Засгийн газар, Америкийн Нэгдсэн Улсын Засгийн газар хоорондын замын зураглал"-ын хэрэгжилтийг зохицуулан хяналт тавин ажиллаж байна. "Стратегийн гуравдагч хөршийн түншлэлийн эдийн засгийн хамтын ажиллагааны тухай замын зураглал" болон	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100%
---	---	--------------------------	--	--	---	---	------

	Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ 2023 оны 8 дугаар сарын 1-6-ны өдрүүдэд Америкийн Нэгдсэн Улсад хийсэн албан ёсны айлчлал, Америкийн Нэгдсэн Улсын Төрийн нарийн бичгийн дарга Энтони Ж.Блинкен 2024 оны 8 дугаар сарын 1-ний өдөр Монгол Улсад хийсэн албан ёсны айлчлалын мөрөөр хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний холбогдох биелэлтийг 2025 оны 03/1496 дугаартай албан бичгээр ГХЯ-нд хүргүүлэв. Б. 1998 онд байгуулагдсан "Монгол Улсын Засгийн газар, БНТУ-ын Засгийн газар хоорондын хөрөнгө оруулалтыг харилцан дэмжих, хамгаалах тухай хэлэлцээр"-ийн үр ашгийг дээшлүүлэх үүднээс тус хэлэлцээрийг шинэчлэн байгуулах асуудлаар холбогдох зохицуулалтыг хийн ажиллаж 2025 онд 2 цахим уулзалтыг зохион байгуулсан	
--	--	--

					болно. В. БНСУ-тай байгуулах Эдийн засгийн түншлэлийн хэлэлцээрийн "Худалдаан дахь техникийн саад тотгор" бүлгийн Ажлын хэсгийн гишүүнээр ажиллаж тухай бүр холбогдох судалгааг хийн саналаа хүргүүлж ажиллав.		
5	Худалдаанд тулгарч буй саад хүндрэлийг багасгаж, хөнгөвчлөхөд чиглэсэн бодлогыг тодорхойлон, импортыг орлох салбарыг дэмжих, экспортын өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, гадаад худалдааны тэнцлийг сайжруулахад чиглэсэн худалдааны бодлогыг тодорхойлж, нэгдсэн төлөвлөлт, зохицуулалтаар ханган, хэрэгжилтэд хяналт тавина.	Хэрэгжилтийн явц, хувиар	Экспортыг нэмэгдүүлэх, импортыг орлох, худалдааны тэнцлийг сайжруулахад чиглэсэн бодлого боловсруулж нэгдсэн төлөвлөлт, зохицуулалтаар ханган ажилласан. Худалдааг хөнгөвчлөх, уул уурхайн бус бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай Засгийн газрын 2023 оны 178 дугаар тогтоолын төслийг боловсруулан хэлэлцүүлж батлуулсан.	Тухай бүр судалгаа хийж, санал боловсруулж, холбогдох арга хэмжээг авч ажилласан байна. /100 хувь/	Эдийн засгийн хамтын ажиллагааны бодлого хариуцсан ахлах мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтод заасан албан тушаалын зорилго, зорилт, чиг үүрэгт энэхүү арга хэмжээ хамаарагддаггүй болно. Тус арга хэмжээний хэрэгжилтийг Худалдааны бодлогын хэлтсээс эрхлэн тайлагнана.	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100%
6	Нэгжийн худалдааны (экспорт, импорт)	Хэрэгжилтийн явц, хувиар	Засгийн газрын 2024 оны 9 дүгээр сарын	Тухай бүр шаардлагатай арга	Эдийн засгийн хамтын ажиллагааны бодлого	1-р сар, 2-р сар, 3-р	100%

	санхүүжилтийн үйл ажиллагааны эрхлэх чиг үүргийн хүрээний асуудлаар Монгол Улсын Хөгжлийн банкны үйл ажиллагааг бодлогоор зохицуулах чиглүүлэх арга хэмжээ авч, хяналт тавина.		25-ны өдрийн 92 дугаар тогтоолоор Хөгжлийн банкны үйл ажиллагааг холбогдох хуульд нийцэж байгаа эсэх талаар хяналт шалгалт хийх үүрэг бүхий ажлын хэсгийн бүрэлдэхүүн болон удирдамжийг баталсан. ЭЗХЯ-ны ТНБД-ын 2024 оны 10 дугаар сарын 4-ны өдрийн Б/22 тушаалаар дэд ажлын хэсэг байгуулагдсан. Ажлын хэсгийн зүгээс холбогдох удирдамжийн дагуу холбогдох хяналт, шалгалтын үйл ажиллагааг явуулж ажилласан.	хэмжээг авч ажилласан байна. /100 хувь/	хариуцсан ахлах мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтод заасан албан тушаалын зорилго, зорилт, чиг үүрэгт энэхүү арга хэмжээ хамаарагддаггүй болно. Тус арга хэмжээний хэрэгжилтийг Худалдааны бодлогын хэлтсээс эрхлэн тайлагнана.	сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	
1.3. Эдийн засгийн хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэх чиглэлийг тодорхойлж, нэгдсэн бодлого боловсруулах, төлөвлөх, зохицуулах, түнш орон, олон улсын болон бүс нутгийн банк, санхүү, эдийн засгийн байгууллагуудтай хамтын ажиллагааг хөгжүүлэх, яамны гадаад харилцааны асуудлыг эрхлэн гүйцэтгэнэ.							
7	Эдийн засгийн хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэх чиглэлээр олон улсын болон бүс нутгийн банк, санхүү, эдийн засгийн байгууллагуудтай Эдийн засаг, хөгжлийн яамны эрхлэх асуудлын	Хэрэгжилтийн явц, хувиар	Түнш улс орон, олон улсын байгууллагуудтай эдийн засгийн хамтын ажиллагааг өргөжүүлэх хүрээнд 11 уулзалтыг зохион байгуулсан.	Тухай бүр шаардлагатай арга хэмжээг авч ажилласан байна. /100 хувь/ /100 хувь/	А. Түнш улс орон, ОУБ-ын төлөөлөлтэй хийсэн дараах уулзалтын яриа хэлэлцээний сэдвийг боловсруулж, уулзалтын бэлтгэлийг ханган зохион байгуулсан ба уулзалтын мөрөөр хэрэгжүүлэх арга хэмжээний биелэлтийг	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100%

хүрээнд гадаад
харилцааны асуудлыг
эрхлэн гүйцэтгэнэ.

ханган ажиллаж байна. сар
Үүнд: 1. Монгол Улсын
Тэргүүн шадар сайд
бөгөөд Эдийн засаг,
хөгжлийн сайд
Л.Гантөмөрийн хийсэн
албан ёсны уулзалт: -
БНТУ-ын Худалдааны
сайд Өмөр Болаттай
2025.1.16-нд хийсэн
уулзалт; - БНТУ-ын
Эдийн засгийн гадаад
харилцааны зөвлөлийн
Ерөнхийлөгч Найл
Олпактай 2025.1.17-нд
хийсэн уулзалт; -
БНТУ-ын “Япы Меркези
Холдинг”-ийн Удирдах
зөвлөлийн дарга
Мустафа Башар
Арыолуг 2025.5.2-нд
хүлээн авч уулзсан
уулзалт. 2. ЭЗХЯ-ны
ТНБД И.Батхүүгийн
зүгээс хийсэн албан
ёсны уулзалт: -
Канадын Гадаад
хэргийн яамны Зүүн
хойд Азийн хэлтсийн
дарга Кен Ингланд
тэргүүтэй
төлөөлөгчдийг
2025.6.3-нд хүлээн авч
уулзсан уулзалт. 3.
ЭЗХЯ-ны ЭЗХАХ-ийн
даргын зүгээс Оманы
хөрөнгө оруулалтын
газрын удирдлагын
багийн гишүүдтэй

						2025.5.23-нд хийсэн уулзалтын бэлтгэлийг ханган ажиллав. Б ЭЗХЯ болон хөгжлийн түншүүдийн зөвлөлдөх уулзалтыг “Хувийн хэвшлийн үйл ажиллагааг өргөжүүлэх, бизнес, хөрөнгө оруулалтын орчинг сайжруулах” сэдвийн хүрээнд багийн нөхдийн хамт 2025 оны 3 дугаар сарын 10-ны өдөр зохион байгуулсан. Зөвлөлдөх уулзалтад Элчин сайдын яамд, хөгжлийн түншүүдийн 38 төлөөлөгч оролцсон. Миний бие хариуцан ажилладаг түншүүдийн төлөөллийг урих, мэдээллээр хангах, уулзалтын нэгдсэн тэмдэглэлийг хөтлөх ажлыг хариуцан гүйцэтгэсэн болно. В. “Монголын эдийн засгийн чуулган-2025” арга хэмжээг ЭЗХЯ хамтран зохион байгуулахтай холбогдуулан дараах ажлыг хийж гүйцэтгэв. Үүнд: - Чуулганд урих гадаадын төлөөлөгчдийн жагсаалтыг нэгтгэн
--	--	--	--	--	--	--

				боловсруулж, урилгын агуулгыг бэлтгэсэн. - Чуулганы бэлтгэлийг хангах Дэд ажлын хэсэгт нэр авах албан бичгийг бүх яамдад хүргүүлэв./03/1375/ - Форумын зохион байгуулалтын асуудлаар ТЗҮЭГ-т 03/1477, УИХ-ын Тамгын газарт 03/1607, Монгол Улсын Шадар сайд С.Амарсайханд 01/1596 дугаартай албан бичгийг тус тус хүргүүлсэн.	
--	--	--	--	---	--

НЭМЭЛТ АЖЛЫН БИЕЛЭЛТ

№	Үүрэг даалгавар	Өгсөн субъект	Биелэлт
1	2	3	4

ХОЁР. МЭДЛЭГ ЧАДВАРАА ДЭЭШЛҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				Биелэлтийн хувь
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин / биелэлт	Эхэлсэн, дууссан хугаца	
1	2	3	4	5	6	7	
4.1. Төрийн албаны тухай хууль, салбарын хууль, дагалдан гарсан хууль тогтоомжид заасан мэдлэг чадварыг эзэмших, тасралтгүй хөгжүүлэх							
1	Эрхэлсэн ажлын чиг үүргийн хүрээнд холбогдох сургалт, семинар,	Эрхэлсэн ажлын чиг үүргийн хүрээнд холбогдох	Эрхэлсэн ажлын чиг үүргийн хүрээнд холбогдох	Тцхай бүр холбогдох сургалт, семинар, хэлэлцүүлэгт	Эрхэлсэн ажлын чиг үүргийн хүрээнд тухай бүр холбогдох сургалт, семинар, хэлэлцүүлэгт	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар,	100%

хэлэлцүүлэгт хамрагдах замаар өөрийн мэдлэг, ур чадварыг дээшлүүлнэ.	сургалт, семинар, хэлэлцүүлэгт хамрагдана.	сургалт, семинар, хэлэлцүүлэгт хамрагдсан.	хамрагдсан байна /100 хувь/.	идэвхтэй хамрагдаж өөрийн мэдлэг, ур чадварыг тогтмол дээшлүүлэн ажилласан болно. Тухайлбал: 1. ХХААХҮЯ, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр, НҮБ- ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллага, СКАЛА төслийн зүгээс Улаанбаатар хотноо 2025 оны 3 дугаар сарын 26-27- ны өдрүүдэд зохион байгуулсан "Жендэрийн хариуцлагатай уур амьсгалын төсөвлөлт" сэдэвт сертификаттай сургалтад хамрагдсан. Сургалтаар жендэрийн хариуцлагатай уур амьсгалын төсөвлөлтийн үндсэн зарчим, оролцогч талуудын үүрэг, салбар дундын зохицуулалтыг хэрхэн хийх талаарх суурь мэдлэг болон гадны улс орнуудын сайн туршлагын тухай мэдээлэл авахын сацуу бодит жишээнд тургуурласан асуудал шийдвэрлэх багийн ажилд идэвхтэй оролцон нийт оролцогчдод Эдийн засаг, хагжлийн яамны чиг үүрэг, тус асуудлаарх оролцооны талаар мэдээлэл өгсөн болно. 2. Гадаад харицааны яам, ХБНГУ-ын Конрад Аденаурын сангаас	7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11- р сар, 12-р сар
--	---	--	---------------------------------	--	--

					хамтран "Монгол Улсын гадаад бодлого, аюулгүй байдал" сэдвийн хүрээнд Улаанбаатар хотноо 2025.05.20-ноос 2025.05.24-нд зохион байгуулсан сургалтад хамрагдаж сертификат авсан. Сургалтаар "Үндэсний аюулгүй байдал, гадаад бодлогын суурь ойлголт", "Жижиг орны аюулгүй байдал", "Монгол Улсын гадаад бодлогын байх суурь", "Нэг цонхны гадаад бодлого", "Гадаад орчинд гарч буй өөрчлөлт, шинэ сорилтууд", "Дипломат ёслол" сэдвээр дэлгэрэнгүй мэдлэг, мэдээлэл авсан. Сургалтаар эзэмшсэн мэдлэг, ур чадварыг ажилдаа тусган ажиллаж байна.		
2	Макро эдийн засаг, олон улсын харилцааны чиглэлэр бие даан судалж өөрийн мэдлэг, ур чадварыг тогтмол дээшлүүлсэн байна.	Макро эдийн засаг, олон улсын харилцааны чиглэлэр бие даан судалж ажиллана.	Макро эдийн засаг, олон улсын харилцааны чиглэлэр бие даан судалж өөрийн мэдлэг, ур чадварыг тогтмол дээшлүүлсэн.	Макро эдийн засаг, олон улсын харилцааны чиглэлэр бие даан судалж өөрийн мэдлэг, ур чадварыг тогтмол дээшлүүлнэ. /100 хувь/	Макро эдийн засаг, олон улсын харилцааны чиглэлээр бие даан судалж өөрийн мэдлэг, ур чадварыг тогтмол дээшлүүлэн ажилласан болно. Тухайлбал: 1. Нобелийн шагналт эдийн засагч Дарон Ажемолу, Жеймс А.Робинсон нарын бичсэн "Why Nations Fail: The Origins of Power, Prosperity and Poverty" буюу	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100%

					“Яагаад улс үндэстэн уналт, доройтолд ордог вэ: эрх мэдэл, хөгжил цэцэглэлт, ядуурлын үндэс” номыг уншив. Улс үндэсний хөгжил, доройтлын үндсэн суурь шалтгаан нь институтын чанар, хөгжлийн ялгаа болохыг түүхэн баримтуудад тулгуурлан гаргаж тавьснаараа энэ бүтээл онцлог, шинэлэг юм. 2. Америк, Ойрхи Дорнодын улс орнуудын түүх, геополитик, орчин цагийн харилцааны асуудлуудын талаар бие даан уншиж судалж, тэдгээр мэдлэг, мэдээллийг эрхэлсэн ажилдаа ашиглаж ажилласан. 3. АНУ-ын Еранхийлөгч Доналд Трампын 2025 онд шинээр гаргасан захирамж, шийдвэрүүдийг нэгтгэн судалж, тэдгээрийн үр нөлөөний талаар анализ хийсэн.	
--	--	--	--	--	--	--

ТАЙЛАНТАЙ ТАНИЛЦСАН:

Төрийн захиргааны газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Төмөр Баясгалан /...../

Огноо:

ТАЙЛАН ГАРГАСАН:

Эдийн засгийн хамтын ажиллагааны бодлого хариуцсан ахлах мэргэжилтэн, Сайнжаргал Анхсайхан /...../

Огноо: 2025.06.28

